



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 09 сарын 02 өдөр


Дугаар 429

Улаанбаатар хот

Дотоод хяналт, шалгалт
зохион байгуулах тухай

Монгол Улсын Эрүүл Мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалт, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол, 2017 оны 89 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалын хэрэгжилтийг ханган ТУШААХ нь:

1. Байгууллагын үйл ажиллагаанд хийх дотоод хяналт, шалгалтын удирдамжийг хавсралтаар тус тус баталсугай.
2. Байгууллагын үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтыг чанартай хийж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Хүний нөөц, дотоод хяналтын ажилтан (Г.Гантуяа)-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллахыг Чанарын менежер (Д.Дашдэлэг)-т даалгасугай.



Багахангай Эрүүл мэндийн төвийн даргын
2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн
129 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт

9020110134 СБГД-12844 1653202

БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙХ ДОТООД
ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН УДИРДАМЖ

ЗОРИЛГО

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үйл ажиллагаанд хэрэгжиж байгаа тушаал шийдвэрийн биелэлт, түүний үр дүнд хяналт хийж, чанарыг сайжруулахад шалгалтын гол зорилго оршино.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ЧИГЛЭЛ

- Гүйцэтгэлийн төлөвлөгөө
- Нийгмийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний чиглэлээр хэрэгжиж байгаа үндэсний хөтөлбөр
- Анхан шатны бичиг баримтын хөтлөлт
- Эмийн сангийн үйл ажиллагаа
- Лабораторийн үйл ажиллагаа
- Няравын үйл ажиллагаа

ХУГАЦАА

2023 оны 09 дүгээр сарын 2-ноос 10 дугаар сарын 02-ны хооронд зохион байгуулна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ АЖЛЫН БҮРЭЛДЭХҮҮН

- Чанарын менежер
- Хүний нөөц, дотоод хяналтын ажилтан
- Ахлах сувилагч

ХҮРЭХ ҮР ДҮН

Байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, жилийн эцсийн тайлан биелэлтийн хэрэгжилтийн хувийг нэмэгдүүлж, удааширалтай байгаа заалтуудын хэрэгжүүлэх, ажлын чанарыг сайжруулна.